



МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗАР

БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

## ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2024 БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛ

10  
АНГИ

# НИЙГЭМ СУДЛАЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг: .....

Сум / сургууль: .....

Анги / бүлэг: .....

Сурагчийн овог: .....

Сурагчийн нэр: .....

Сурагчийн код: .....

САНАМЖ

- Даалгаврыг 40 минутад гүйцэтгээрэй.
  - Даалгавар тус бүрийн зааврыг сайн уншаарай.
  - Сонгох даалгавар тус бүрээс зөвхөн нэг хариултын хувилбарыг сонгож, хариултын хуудсанд зааврын дагуу харандаагаар будаарай.

## НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: СОНГОХ ДААЛГАВАР

1. Нийгмийн институтийн нэг болох боловсролд хамаарах ойлголтуудыг сонгоно уу.

1. Мэдлэг, соёлыг дамжуулах  
3. Гишүүдийг өсгөж хүмүүжүүлэх  
5. Нийгмийн эв нэгдэл, зөвшилцлийг тогтоох

2. Гишүүдээ нийгэмшүүлэх  
4. Боловсон хүчнийг бэлтгэх  
6. Үл мэдэх зүйлст хариулт өгөх

A. 1, 2, 4                    B. 1, 2, 3, 4                    C. 1, 4, 6                    D. 4, 5, 6

2. Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү.  
..... нь үйлдэгч урьдчилан тооцоолоогүйгээр бий болсон үр дагавар юм.

A. Үүрэг                    B. Ил чиг үүрэг                    C. Далд чиг үүрэг                    D. Сөрөг чиг үүрэг

3. Дараах ойлголтуудаас чанарын судалгаанд аль нь хамаарах вэ?

A. Мэдээлэл цуглуулах үйл явц 1 ижил горимоор явагдана.  
B. Стандарчлагдсан загварын дагуу үр дүнг нэгтгэн бичнэ.  
C. Хэмжилт мэдээлэл цуглуулах явцад эсвэл дараа нь хийгдэнэ.  
D. Цөөн тооны хувьсагч хоорондын хамаарлыг шалгахад анхаарна.

4. Нийгмийн судалгааны асуулгын арга нь 5 хэсэгтэй. Үүнээс төгсгөл хэсэгт хамаарах өгөгдөл аль нь вэ?

A. Хувь хүний нийгмийн байр суурийг тодруулах асуултууд байна.  
B. Судлаачдын холбоо барих утас, хаяг зэргийн талаарх мэдээлэл байна.  
C. Судалгаанд баримталж буй ёс зүйн хэм хэмжээний тухай асуултууд байна.  
D. Мэдээлэл цуглуулсан орон нутгийн нэр, огноо, мэдээлэл цуглуулагчийн нэр байна.

5. Хүснэгтэд байгаа тулгуур ойлголтуудыг тохирох тайлбартай нь зөв харгалзуулна уу.

а) Үнэлэмж б) Үнэлэмжийн баримжаа с) Үнэлгээ	1	Сайн үйл, шударга ёс, эрх чөлөөг аль ч ард түмэн эрхэмлэдэг.
	2	Нийгмийн бүхий л харилцааг журамлаж, зөв сайхан амьдрах арга ухаанд суралцах, төлөвшихөд тусалдаг.
	3	Хувь хүний танин мэдэх үйл ажиллагааны үр дүнд бий болсон асуудлыг зөв шийдэх арга хэрэгсэл юм.
	4	Бид аливаа үйл явдал, үзэл санааг дэмжих, буруутгах, шүүмжлэх, магтах зэргээр янз бүрээр үнэлж, дүгнэж байдаг.
	5	Хүмүүс үзэл санаа, итгэл үнэмшил, ёс суртахууны хувьд харилцан адилгүй сонголт хийдэг.

- A. a1, b5, c4      B. a2, b5, c4      C. a2, b5, c3      D. a1, b2, c4

6. “Соёл нь хүн нийгмийн гишүүн болохынхоо хувьд эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, урлаг, ёс суртахуун, хууль, зан заншил болон бусад чадвар дадлуудыг багтаасан цогц бүхэл юм” гэж дараах философичдын аль нь үзсэн бэ?
- A. А. Гидденс      B. Э. Кассирер      C. Э. Тайлор      D. Р. Бенедикт
7. Монгол улсын Соёлын тухай хуульд “Соёлын үнэт зүйл гэдэгт гоо сайхны үзэл баримтлал, эх хэл, бичиг үсэг, аман аялгуу, уламжлалт технологи, газар усны нэр, зан заншил, бэлгэ тэмдэг, ардын аман зохиол гэх мэт хамаарна” гэж заасан байгаа нь дараах ойлголтуудын алийг нь илэрхийлж байна вэ?
- A. Соёлын нэгдмэл шинж      C. Соёлын түгээмэл шинж  
B. Соёлын харьцангуй шинж      D. Соёлын олон янз байдал
8. Дараах жишээ, баримтаас аль нь нэг хэв загварын соёлыг илэрхийлж байна вэ?
- A. Бат 22 настай бөгөөд хүй нэгдлийн, эртний, дундад зууны, сэргэн мандалтын, шинэ үеийн, орчин үеийн нийгмийг бүхэлд нь судалж үзэх сонирхол бөгөөд дипломын ажлаа соёлын түүхэн хэв маяг гэсэн сэдвээр хамгаалахаар болжээ.  
 B. Оюутан Дорж нь ан агуул, түүвэрлэгчдийн соёл, нүүдэлчдийн соёл, газар тариаланчдын соёлын тухай мэдээлэл цуглувалж нийтлэл бичсэн байсныг найд нь уншиж ерөнхий чиг баримжаа, ойлголттой болсон билээ.  
 C. 1959 оны дунд үеэс иргэдийг бичиг үсгийн мэдлэгтэй болгох, ариун цэвэр, соёлч ахуйг хүмүүсийн амьдралд нэвтрүүлж хүүхэд багачуудыг өвчнөөс хамгаалах олон талт ажлуудыг төрөөс зохион байгуулахаар болсон гэдэг.  
 D. Оюутан Доржийн нийтлэлийн гол санаа нь нийгэм болон нийгмийн хэсэг бүлгийн оюун санаа, материаллаг байдал, мэдлэг, оюун сэтгэл санааны шинж байдлын тухайд үндэслэн тайлбарласан.
9. Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн түвшинд нөлөөлдөг болохыг судлан гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ хэдий их байна, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ төдий чинээ өндөр болдгийг тогтоосон судлаач аль нь вэ?
- A. Оуэken      B. Фишер      C. Кейнс      D. Хайек
10. Хүснэгтээс мөчлөгийн ажилгүйдлийн тодорхойлолт болон жишээг олно уу.

Хүснэгт-a		Хүснэгт-b	
1	Эдийн засгийн уналттай холбоотой үүссэн ажилгүйдэл	1	Улс төрийн нэг нам ялснаар нөгөө намын төрийн албан хаагчид ажилгүй болсон.
2	Шилжих хөдөлгөөнтэй холбоотой үүссэн ажилгүйдэл	2	Д-н цалин нь амьдралд хүрэлцэхгүй байгаа тул өөр өндөр цалинтай ажил хайхаар ажлаасаа гарсан.
3	Эдийн засгийн салбаруудын хувийн жин болон ажлын эрэлтийн өөрчлөлттэй холбоотой үүссэн ажилгүйдэл	3	А-н нөхөр нийслэлд ажиллахаар томилогдсон тул А нь хотод ирээд хэсэг ажилгүй болсон.

- A. a-1, b-2      B. a-1, b-3      C. a-3, b-1      D. a-2, b-1

11. Инфляцын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөлд үл хамаарахыг олно уу.

- A. Бараа, үйлчилгээний нийт эрэлт муудна
- B. Бараа бүтээгдэхүүний үнэ өснө
- C. Зээлдүүлэгчдэд ашигтай нөхцөл бий болно
- D. Эдийн засгийн дотоод тэнцвэрийг алдагдуулна

12. Өсөлтийн хурдны тухайн оны түвшинг өмнөх оны түвшинд хувааснаар ямар үзүүлэлтийг харах вэ?

- A. Өсөлтийн хурдыг коэффициентээр тодорхойлж болох ба энэ нь үзүүлэлт хэдээр өссөн болохыг харуулна.
- B. Өсөлтийн хурдыг коэффициентээр тодорхойлж болох ба энэ нь үзүүлэлт хэд дахин өссөн болохыг харуулна.
- C. Өсөлтийн хурдыг коэффициентээр тодорхойлж болох ба энэ нь үзүүлэлт хэдээр буурсан болохыг харуулна.
- D. Өсөлтийн хурдыг коэффициентээр тодорхойлж болох ба энэ нь үзүүлэлт өсөлт, бууралт байхгүй болохыг харуулна.

Тохиолдлыг уншаад 13-15 дугаар даалгаврыг гүйцэтгээрэй.

Иргэн Д нь 30 настай бөгөөд “Тоёото” корпорацад 12 сар тасралтгүй ажиллаж нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн. Д нь удирдлагын хэлтсийн санаачилгаар ажлын 14 хоног илүү цагаар ажилласан. Гэвч цалин олгоход илүү цагийн хөлсийг иргэн Д-д олгоогүй. Мөн иргэн Д нь ердийн өвчнөөр хөдөлмөрийн чадвараа түр алджээ. Иргэн Д-н оронд “Тоёото” корпорацын ажил олгогч нь Б гэдэг 16 настай иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллуулсан байна.

13. Иргэн Д нь илүү цагийн хөлсийг авах ёстой юу? Яагаад?

- A. “Тоёото” корпорац нь үндэстэн дамнасан корпорац учир илүү цагийн хөлсний мөнгийг монголын хөдөлмөрийн тухай хуулиар олгодоггүй.
- B. Тухайн сарын ажлын бүх өдөр илүү цагаар ажиллавал хөдөлмөрийн тухай хуулийн 53-р зүйлийн 1-д зааснаар илүү цагийн хөлсийг олгох ёстой.
- C. 7 хоногт 40 хүртэл ажилласан бол хөдөлмөрийн тухай хуулийн 53-р зүйлийн 1-д зааснаар илүү цагийн хөлсийг олгох ёстой.
- D. Ажил олгогчийн санаачилгаар хэтрүүлэн ажиллахыг илүү цагаар ажилласанд тооцдог тул илүү цагийн хөлс олгох ёстой.

14. Иргэн Б нь “Тоёото” корпорацтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллаж болох уу?

- A. 18 нас хүрээгүй тул хөдөлмөрийн гэрээний нэг талаар ажиллаж болохгүй.
- B. Эцэг эхийн зөвшөөрлөөр хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллаж болно.
- C. Ажлын чиг авах зорилгоор хөдөлмөрийн гэрээний нэг талаар ажиллаж болно.
- D. Өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээний нэг талаар ажиллаж болно.

15. Иргэн Д нь хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авах нөхцөл бүрдсэн үү?

- A. Нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар тасралтгүй төлсөн ч ердийн өвчнөөр хөдөлмөрийн чадвараа түр алдсан тул тэтгэмж авах эрх үүсэхгүй.
- B. Иргэн Д нь нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар тасралтгүй төлсөн тул тэтгэмж авах эрх үүссэн.
- C. Иргэн Д нь нийгмийн даатгалын шимтгэлийг 24 сар тасралтгүй төлөөгүй тул тэтгэмж авах эрх үүсэхгүй.
- D. Иргэн Д нь ажил үүргээ гүйцэтгэж байгаад ажлын байрандаа осолдсон бол тэтгэмж авах эрх үүссэн.

**16.** Дараах өгөгдлүүдийн аль нь /“Хөдөлмөрийн тухай хууль”-ийн 21 зүйлийн 21.1-д заасан/ хөдөлмөрийн гэрээнд тусгасан нөхцөл вэ?

Өгөгдөл: /1-Ажлын байрны буюу албан тушаалын нэр; 2-ажлын байрны тодорхойлолтод заасан ажил, үүрэг; 3-Ажлын байрны чиг үүрэг, эдлэх эрх; 4-Ажлын байр дахь хариуцлагын тогтолцоо; 5- Үндсэн цалин буюу албан тушаалын цалингийн хэмжээ; 6-Хөдөлмөрийн нөхцөл/

- A. 1, 3, 4, 5      B. 1, 2, 5, 6      C. 1, 3, 5, 6      D. 1, 3, 4, 6

**17.** Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн Үндсэн хуулийн болон бусад хууль тогтоомж нь хүн бүрд тэгш үйлчлэх явдлыг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Үндсэн хуулийн суурь зарчим      C. Эрх зүйд захирагдах ёс  
B. Иргэний эрх зүйн харилцаа      D. НҮБ-ын хүний эрхийн суурь зарчим

**18.** 1990 оноос өмнөх төрийн бодлогуудыг сонгоорой.

a) 1990 оны өмнөх төр	1	Төвлөрсөн төлөвлөлтөөр нийгмээ хөгжүүлэх
	2	Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд хэм хэмжээ тогтоох
	3	Ардчилсан зарчмыг улс төрийн кампани болгож төлөвлөх
	4	Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй
	5	Хүний эрхийн түгээмэл зарчмуудыг хэрэгжүүлэх

- A. a-1, 2, 3      B. a-2, 3, 4      C a-2, 3, 4, 5      D. a-1, 2, 4

**19.** Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү.

..... нь хуулийг хэрэгжүүлэх, удирдан чиглүүлэх, зохион байгуулах, төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах, төрийн залгамж чанарыг хадгалах, нийгмийн аюулгүй байдлыг хангах, дэг журмыг тогтоох үүрэгтэй.

- A. Төр      B. Эрх мэдэл      C. Сайн засаглал      D. Гүйцэтгэх засаглал

**20.** Дараах өгөгдлүүдээс аль нь Монгол улсын иргэний журамт үүрэг вэ?

Өгөгдөл: /1-Хуулийг дээдлэн хүндэтгэх, сахин биелүүлэх; 2-Хөдөлмөрлөх; 3-Байгаль орчноо хамгаалах; 4-Эрүүл мэндээ хамгаалах; 5-Эх орноо хамгаалах, цэргийн алба хаах; 6-Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх; 7-Yр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх; 8-Албан татвар төлөх/

- A. 1, 5, 6, 8      B. 1, 3, 6, 8      C. 2, 3, 4, 7      D. 2, 4, 5, 7

**21.** Цэгийн оронд тохирох ойлголтыг нөхнө үү.

..... гэдэг нь иргэн өөрийн улсдаа төдийгүй гадаадын улс оронд сурх, ажиллах, бизнес эрхлэх, худалдаа арилжаа хийх, аялах жуулчлах зэрэг үйл ажиллагаагаар илрэх харилцаа юм.

- A. Олон улсын харилцаа      C. Олон улсын харилцааны улс бус оролцогч  
B. Олон улсын харилцааны эрх зүй      D. Иргэн олон улсын харилцааны оролцогч

**22.** Олон улсын эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэрийг де-факто гэнэ. Тэгвэл монгол улс хэд оныг хүртэл де-факто хэлбэрээр хүлээн зөвшөөрөгддөг байсан бэ?

- A. 1945 он      B. 1948 он      C. 1961 он      D. 1990 он

**23.** Олон улсын харилцааны “улс” оролцогчийн нэг болох бага улсад хамаарах ойлголтуудыг олоорой.

1. Голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсууд
2. Олон улсын харилцаанд нөлөө багатай ч өөрийн гэсэн арга хэрэгсэлтэй
3. Өөрийн гадаад бодлогын хүчин чадал бага ч дэлхийн улсуудын 2/3-ыг эзэлдэг
4. Өөрийн хөрш холбоотон улс, бус нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай

A. 2, 3

B. 3, 4

C. 1, 2

D. 2, 4

#### САНАМЖ

- Хоёрдугаар хэсгийн даалгаврыг (2.1; 2.2) гүйцэтгэхдээ хариултын хуудас дахь САНАМЖ хэсэгт байгаа зааврын дагуу хариултыг будаарай.

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

**2.1** Хүснэгт дэх ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

a) Н.Макиавелли b) Д.Истон c) Ш.Монтескье d) Ж.Локк e) Р.Даль	1	Эрх мэдэл хуваарилах онолыг үндэслэсэн
	2	Либерализмын онолыг үндэслэгч
	3	Улс төрийн системийн үндсэн 2 бүлэг болох оролт, гаралтын чиг үүрэг байдгийг тодорхойлсон.
	4	“Улс төр бол нийгэм дэх үнэт зүйлсийг эрх мэдэлд тулгуурлан хуваарилан байршуулах үйл явдал” гэж үзсэн
	5	“Эзэн ван” зохиолыг бичсэнээр улс төрийн шинжлэх ухааны хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан.
	6	Ардчиллын плюралист онолын төлөөлөгч

**2.2** Хүснэгт дэх ойлголтуудыг зөв харгалзуулна уу.

a) ОУХ-нд оролцох үүрэг b) ОУХ-нд оролцох үйл ажиллагааны чиглэл c) ОУХ-нд оролцох нөлөө d) ОУХ e) ОУХ-ны улс бус оролцогч	1	Дэлхийн улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад бодлого, үйл ажиллагааг судалдаг.
	2	ОУХ-нд улс төр, эрх зүй, эдийн засаг, худалдаа, шинжлэх ухаан, хүмүүнлэгийн гэсэн үйл ажиллагаагаар оролцдог.
	3	Улс төрийн гадаад харилцаанд тулгуурласан аж ахуйн хамтын ажиллагаа, гадаад худалдаа хөрөнгө оруулалт зэрэг эдийн засгийн салбаруудын олон талт, цогц үйл ажиллагаа
	4	Монгол улсын гадаад бодлого болон харилцаа нь үндэсний сонирхлыг тусгасан зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа
	5	Засгийн газрын оролцоо, дэмжлэггүйгээр байгуулагдсан, олон улсын байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагаа
	6	ОУ-ын олон талд харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөллөөр тодорхойлгдоно.
	7	МУ бусад улсын улс төр, эдийн засаг, соёлын хүч чадавх, үйл ажиллагааг өөрийн боломжоор хянах, үнэлэх, дүгнэх